



ДУНДГОВЬ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 08 сарын 09 өдөр

Дугаар А/147

Мандалговь

Г

Гэрээ байгуулах тухай

Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалт, Засаг даргын 2017 оны А/241 тоот захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны 2017 оны 07 сарын 26-ны өдрийн дүгнэлтийг үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Улсын төсвөөс санхүүжигдэх "Эрдмийн далай цогцолбор сургуулийн 1-р дотуур байрны дээврийн засварын ажил"-ын гүйцэтгэгчээр "Дөл БГМ" ХХК-ийг сонгон 57 300 000 / тавин долоон сая гурван зуун мянга / төгрөгөөр гэрээ байгуулсугай.

Хоёр. Батлагдсан зураг төсвийн дагуу засварын ажлыг чанартай хийж гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг "Дөл БГМ" ХХК –ний захирал /Г.Буджав/ - д үүрэг болгосугай.

Гурав. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга /Н.Эрдэнэ-Очир/, Эрдмийн далай цогцолбор сургуулийн захирал /Г.Туяамандах/ нарт тус тус үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ЭРДЭНЭСҮРЭН



0300474